

ОРОС-ХЯТАДЫН ӨНӨӨГИЙН ХАРИЛЦАА*Н.Мандхай**

Манай орны хөрш орон болох Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоёрын харилцаа нь түүхэн ээдрээтэй үеийг даван туулсан билээ. Орос-Хятадын харилцаа өнөөдөр стратегийн түншлэлд хүрчээ. Хоёр их гүрний хооронд “хавчигдсан” геополитикийн өвөрмөц байршилтай манай орны хувьд Орос-Хятадын харилцаа ихээхэн нөлөө үзүүлсээр ирсэн. Монгол Улсын Гадаад бодлогын Үзэл баримтлалд: ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Ингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана.¹ Иймд хөрш орнуудын харилцааны тэнцвэр, ирээдүйн төлвийг судлах нь маш чухал бөгөөд цаашид манай орны хөгжилд үлэмж ач холбогдолтой. Орос-Хятадын харилцааны тэнцвэрээс зөвхөн Монгол Улсын оршин тогтнол, дэвшил, хөгжил, Зүүн Хойт Азийн бүс нутгийн уур амьсгал, аюулгүй байдал, хамаарах төдийгүй дэлхийн дахины хүчний тэнцвэрт ч чухал нөлөөтэй.

Зөвлөлт-Хятадын харилцааны үеийг товчхонд нь авч үзвэл, тухайлбал:

1949 оны 10 дугаар сарын 1-ний өдөр БНХАУ байгуулагдсан. Манжуурт Зөвлөлтийн цэргүүд Японы Квантуны армийг бут цохисноор Хятадын талд ихээхэн тус үзүүлсэн юм. Үүний үр дүнд Мао Цзэдүн тэргүүтэй Хятадын Коммунист нам засгийн эрх барьсан.

1949 оны 10 дугаар сарын 2-ны өдөр ЗСБНХУ, БНХАУ хоёр хоорондоо дипломат харилцаа тогтоосон.

1949-1956 онд Зөвлөлт-Хятадын харилцаа шинэ шатанд хүрсэн үе. ЗХУ Хятадын талд арми байгуулах, мэргэжилтэн бэлтгэх ажилд идэвхитэй туслаж, Далянь хот, Дорнод Хятадын төмөр зам /КВЖД /-ыг Хятадын талд буцааж өгсөн.

1956 онд ЗХУ-д Н.С.Хрущёв засгийн эрх барьж Зөвлөлтийн коммунист намын XX их хурлын дараа хоёр орны харилцаа хүйтэрч эхэлсэн байна. 1963 онд ЗХУ, ХКН-ын удирдлагууд хоорондоо захидлаар харилцаж үзэл суртлын асуудлаар мэтгэлцэх болсон. 1964 оноос эхлэн Орос-Хятадын харилцаа зогсонго байдалд оров. Түүний оргил үе 1969 он бөгөөд Алс Дорнодын Даманскийн хойг, Казахстаны Жаланашколь нуурын орчим Орос-Хятадын хил дээр зэвсгийн

* Н.Мандхай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

мөргөлдөөн болсон. Орос-Хятадын харилцааны “хүйтрэлийг” коммунист үзэл суртлын зөрчил гэж үздэг.

Орос-Хятадын харилцааны шинэ үе:

1991 онд Зөвлөлт задарсны дараа түүний өв залгамжлагч ОХУ, БНХАУ хоёрын харилцааны шинэ үе шат эхэлсэн. 1991 оны 5 дугаар сарын 16-нд ЗСБНХАУ, БНХАУ хоёр Зөвлөлт-Хятадын улсын хилийн зүүн хэсгийн тухай Хэлэлцээр баталсан. 2001 онд ОХУ, БНХАУ хоёр найрсаг харилцаа, найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээ² байгуулсан.

2004 оны 10 дугаар сард хоёр орны тэргүүнүүд тус Гэрээний 2005-2008 оны хөтөлбөрийг баталсан.³ Тус баримт бичиг нь Орос-Хятадын харилцааны дунд хугацааны хөтөлбөр бөгөөд олон улсын тавцан дээрх хоёр улсын байр суурийг илэрхийлдэг юм. Мөн үүний зэрэгцээ хамтын ажиллагааны бүхий л салбарт Засгийн газар, холбогдох байгууллагууд хооронд гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулав.

Хоёр орон албан ёсоор харилцаагаа сэргээж, 1996 оноос хойш хоёр орны тэргүүнүүд жил болгон уулзаж эхэлсэн. Сүүлийн үед ОХУ, БНХАУ хоёрын тэргүүнүүдийн уулзалт жилд 3-аас доошгүй болж өнгөрдөг бөгөөд үүнд хоёр талын уулзалт, ШХАБ-ын хүрээнд дээд хэмжээний уулзалт, АПЕК-н хүрээнд уулзалтууд орж байна. 2006 онд 6 удаагийн уулзалт болсон байх жишээтэй.

2006 оны 3 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Хятадад хийсэн албан ёсны айлчлалын үр дүнд улс төр, дипломат, эрчим хүчний салбар, хөрөнгө оруулалт, санхүү, тээврийн салбарт нийт 22 баримт бичиг бичигт гарын үсэг зурсан.⁴ Үүний гол үр дүн нь Орос Хятадад 1 жилд 60-80 тэрбум кубометр газрын хий нийлүүлэхээр болжээ. Дорнод, Баруун Сибирээс /“Алтай” хоолой/ Хятад руу 2 хоолой татах юм байна. Оросыг Барууны зах зээлээс хараат бус болгох зорилготой байна гэж В.Путин мэдэгдсэн. Роснефть компани нь Хятадын талтай хамтран Ненецкий автономит тойрог, Красноярскийн хязгаар, Карский, Чукотский, Баренцевын тэнгисүүд, “Сахалин-3” төслийн хүрээнд орд газруудаа ашиглахаар тохиролцоонд хүрсэн. Мөн цаашид хоёр тал үйлдвэрүүдээ хамтран ажиллуулах замаар үндэсний болон бүс нутгийн эдийн засгаа хөгжүүлэхээр тохирчээ. Олон шинжээчдын үзсэнээр, Орос-Хятадын стратегийн түншлэл нь дэлхийн геополитикийн хүчний тэнцвэрийг өөрчилнө гэж үзэж байна.⁵ Тус айлчлал нь Орос, Хятадын стратегийн хамтын ажиллагааны 10 жилийн ой болон ОХУ, БНХАУ-ын хоёрын найрсаг харилцаа, найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээний 5 жилийн ойн хүрээнд болж өнгөрсөн.

2007 оны 3 дугаар сарын 26-28-нд Хятадын удирдагч Ху Цзиньтао ОХУ-д айлчлав. Оросын Ерөнхийлөгч В.Путинтэй уулзаж, Орост Хятадын жилийн албан ёсны нээлтийг хийсэн. Айлчлалын үр

дүнд ЗГ, холбогдох байгууллагуудын хооронд болон арилжааны 9 баримт бичигт гарын үсэг зурж Хамтарсан тунхаглал баталж, үүнд хоёр орны стратегийн түншлэлийн 10 жилийн ойн баярт зориулан энэ хугацаанд хамтын ажиллагаандаа дүгнэлт хийсэн.

Хайлигендамд болж өнгөрсөн “Их найм”-ын бүлгийн хүрээнд ОХУ, БНХАУ-ын Ерөнхийлөгч нар 2007 оны 6 дугаар сарын 8-нд уулзсан. Мөн ШХАБ-ын гишүүн орнуудын тэргүүнүүдийн Зөвлөлийн хуралдаан дээр 2007 оны 8 дугаар сарын 16-нд, Чебаркулд терроризмын эсрэг зохион байгуулсан цэргийн сургалтын үеэр 8 дугаар сарын 17-нд тус тус уулзав.

2004 оны 9 дүгээр сарын 24-нд Москва хотноо Ерөнхий сайдуудын 9 дэх уулзалт болж, ОХУ-ыг ДХБ-д элсэх талаар Хятадын талтай хийсэн хэлэлцээ дуусаж, Орос, Хятад хоёр нь бие биенээ зах зээлийн эдийн засагтай орон гэж хүлээн зөвшөөрсөн. Ерөнхий сайдуудын 11 дэх уулзалт Бээжин хотноо 2006 оны 1 дүгээр сарын 9-нд болсон. Үүний үр дүнд хамтарсан мэдэгдэл гаргаж хоёр талын олон талт хамтын ажиллагааг өндөр үнэлжээ.

2005 оны 6 сард ОХУ-ын Төрийн думын дарга Б.В.Грызлов Хятадад айлчилж, хоёр орны парламентын тэргүүнүүд⁶ Төрийн дум, Хятадын ардын төлөөлөгчдийн хурлын хоорондын хамтын ажиллагааны Орос-Хятадын парламентын комиссын дүрмийг батлав. Үүний дагуу хоёр орны парламентын хооронд байнгын механизм ажиллаж эхэлсэн.

Орос-Хятадын парламент хоорондын харилцаа ийнхүү идэвхитэй хөгжих болов. Сүүлийн үед 1 жилд 1-ээс доошгүй уулздаг болсон. Оросын Төрийн Дум болон Холбооны Зөвлөл, Хятадын Ардын төлөөлөгчдийн хурлын хүрээнд парламент хоорондын комиссууд тус тус байгуулагдаж, парламентын төлөөлөгчид санал солилцож, Орос-Хятадын найрамдлын бүлгүүдийн хүрээнд харилцан туршлага солилцдог болжээ.⁷

Хоёр талын бүс нутаг, мужуудын хоорондын холбоо идэвхжиж, 100 гаруй гэрээ, хэлэлцээр баталсан байна. Одоо Оросын 70 гаруй субъектууд /Орост нийт 89 субъект бий/ Хятадын мужуудтай шууд харилцаа тогтоосон байна.⁸

Цэргийн салбарын хамтын ажиллагаа:

2004 оны 10 дугаар сарын 14-нд хоёр орны тэргүүнүүдийн гарын үсэг зурсан “ОХУ болон БНХАУ хоёрын хоорондын улсын хилийн зүүн хэсгийн тухай нэмэлт Хэлэлцээр”⁹-ийг 2005 онд ОХУ-ны Төрийн Дум болон БНХАУ-ын Ардын төлөөлөгчдийн хурлаар баталсан. Үүгээр хоёр орны хооронд 1964 оноос эхэлсэн хилийн маргаан дуусгавар болов. Тус хэлэлцээрээр Чита мужийн Аргунь голын Большой арал,

Амур голын Тарабаров болон Большой Уссурийский арлуудын хилийн шугамыг тодорхойлсон. Энэ хилийн шугамын хэсгүүд хоёр улсын хилийн нийт 4,3 мянган км уртын 2%-иас бага хувь эзэлдэг бөгөөд өмнөх 1991 оны Хэлэлцээрт ороогүй байсан юм.

2005 онд Орос, Хятад хоёр хилийн маргаантай асуудлаа ийнхүү эцэслэн шийдвэрлэж чадав. Мөн оны 8 дугаар сард цэргийн хамтарсан анхны сургалт явуулсан.

Мөн стратегийн аюулгүй байдлын асуудлаар байнгын механизм бий болж, Орос-Хятадын хамтын ажиллагааг зохицуулж байгаа юм. Энэ хүрээнд Оросын Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга И.С.Иванов, Хятадын Төрийн Зөвлөлийн гишүүн Тан Цзясюань хоёрын 2 удаагийн уулзалт болсон.¹⁰ Ийм хамтын ажиллагаа нь хоёр оронд шинээр бий болж байгаа аюул заналхийлэлээс зайлсхийж хамтран арга хэмжээ авах, нийтлэг ашиг сонирхлоо хамгаалахад ач тустай гэж үздэг.

Орос, Хятад, Казахстан, Киргиз, Таджикистан болон 5 орон 1996 онд баталсан Цэргийн салбарт итгэлийг бататгах¹¹ Шанхайн хэлэлцээр, 1997 онд баталсан Москвагийн хэлэлцээр болон хуучин Зөвлөлт-Хятадын хил дээр харилцан зэвсэгт хүчин цөөрүүлэх тухай хэлэлцээр¹² тус тус амжилттай хэрэгжиж байна.

2001 онд “Шанхайн тав”-ын үндсэн дээр Шанхайн хамтын ажиллагааны байгууллага бий болж сүүлд Узбекистан элссэн.¹³

Гэвч энэ асуудалд Оросын зарим шинжээчид эсрэг байр суурьтай байгаа юм. Хятадын батлан хамгаалах үйлдвэрлэл нь технологийн хувьд 15-20 жилээр хоцорсон. Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд Хятад нь Оросын оюуны болон технологийн нөөцийг идэвхитэй ашиглаж байна.¹⁴ Хятадын Ардын чөлөөлөх армийн 4 дэх шинэчлэлийн явцад “үй олны армийн” хэлбэрээс үндэсний нутаг дэвсгэрээс гадна цэргийн үйл ажиллагаа явуулах чадвартай өндөр технологиор зэвсэглэсэн маш шуурхай “цэргийн бүтэцэд” шилжихээр төлөвлөжээ. Үүний тулд БНХАУ-ын удирдлагын үзснээр, холын авиаци, усан флотыг сайжруулж цэргийн дайрах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнийг сүүлийн жилд Хятадын талын Оросоос импортлосон цэргийн техникийн бүтэц нотлож байна гэж Оросын тал үзэж байгаа. Хятадын талын худалдаж авч буй зэвсгийн техникийн чадавхи нь нэмэгдэж, үүнд “Москист” маркийн далавчтай ракетээр зэвсэглэсэн 956Э төслийн эсминц, 636 төслийн усан шүмбагч хөлөг, СУ-32ФМ маркийн байлдааны онгоц авах болсон. Харин ОХУ-ын өөрийн зэвсэгт хүчин нь экспортод явж байгаа техникийн багахан хувийг л хэрэглэдэг. Оросын зарим шинжээчид үүнийг маш ихээр шүүмжилж, Оросын Зэвсэг үйлдвэрлэлийн ноу-хау Хятадыг бүрэн

хангаж, харин Орос улс нь өөрөө ирээдүйд аюулгүй байдлаа хангах чадваргүй болж магадгүй гэж шүүмжилдэг.

Хятадын “оюуны мэдлэгийн хулгайчид” /*headhunting*/Оросын эрдэм шинжилгээний багуудын судалгаанд маш ихээр анхаарал тавьж энэ нь Хятадын сансрын хөтөлбөр болон сансрын туршилт, цөмийн үйлдвэрлэлийн хөгжилд хэрэгтэй гэж үздэг байна. Харин хэдэн жилийн дараа Оросын технологи Хятадад хэрэггүй болж мэдэх юм.

ОХУ, БНХАУ хоёр хоорондын Зэвсэгт хүчнийг харилцан цөөрүүлэх Хэлэлцээрийг батлаж хоёр талаас улсын хилийн дагуу зэвсэг хэрэглэх 100 км-ын гүн руу холдуулж тодорхой зэрэглэлийн цэрэг, зэвсэг хэрэглэхийг хязгаарлахаар тохиролцсон /Хабаровск, Владивосток хотууд орохгүй/. Үүний дагуу 4433 км урттай Орос-Хятадын улсын хилийн дагуу 15-20 дивизийн түвшний цэргийн бүтэц хоёр тал байрлуулах ёстой. Эл хэлэлцээрийн дагуу эдгээр нь тус газрын 1/5-ыг хамгаалах боломжтой. Хилийн отрядуудыг тооцохгүйгээр, 3500 км урттай Оросын талын хил нь бараг хамгаалалтгүй байна гэж Оросын талын зарим шинжээчид ярьдаг.

Гэвч тус Хэлэлцээрийн дараа Оросын тал шинэ асуудлуудтай тулгарч эхэлсэн. Цэргийн байршилыг 100 км-ээр улсын хилээс холдуулсан нь батлан хамгаалах зорилготой цэргийн ангиудын ОХУ-ын Холбооны хилийн цэргийн байгууллагатай харьцах нөхцлийг өөрчлөж, онцгой нөхцөлд яаралтай тусламж авахад хүндрэлтэй болгосон. Мөн батлан хамгаалах системн хэвийн байдал хангагдахгүй болсон. Тус хэлэлцээрийн хугацаа 20 жилийн дараа дуусахад Оросын хил орчмын цэргийн дэд бүтэц нь 100 км зайд байлдааны нөхцөлд шаардлага хангахгүй болж магадгүй юм. Цаг агаар, газар зүйн байршлын нөхцөл, зам тээврийн дэд бүтцийн сүлжээ нь байлдааны нөхцлийг хүндрүүлж цэргийн маневр хийхэд хэцүү болгож, байлдааны багийн өөрчлөлт хийх нь цаг шаардах болно. Цэргийн хүч цөөрүүлэх нь тус газрын хүн амын шилжилтыг дагуулж, олон тооны цэргийн хотхон ирээдүйгүй болж байгаа юм.

Эл байдал нь Оросын талд үндэсний ашиг сонирхолыг хамгаалах үндсэн зорилгод харшлах болно гэж оросын зарим шинжээчид үздэг байна. Тэдгээрийн үзснээр Оросын тал хэт өгөөмөр зан гаргаж, бага үнээр үндэсний баялагаа худалдаж, өөрийгөө хохироход хүргэж болзошгүй гэжээ.

Эдийн засгийн хамтын ажиллагаа:

Орос улс Хятадын хувьд худалдааны томоохон түнш хийгээд зэвсэг, цэргийн технологи, түүхий эдийн томоохон нийлүүлэгч юм. Харин Хятад улс нь Оросын эдийн засгийн хямралтай үед хөнгөн үйлдвэрүүд үйл ажиллагаагаа явуулахгүй учир хямд үнэтэй өргөн хэрэглээний бараа нийлүүлэгч бөгөөд олон тооны ажлын хүчний зах

зээл болсон юм. 2001-2005 онд Орос, Хятадын худалдааны эргэлт нь 10.67-29.1 тэрбум ам.долларт хүрч 1 жилд дунджаар 30%-иар нэмэгдсэн. 2004 онд хоёр орны худалдааны эргэлт нь 21.2 тэрбум ам.доллар, 2006 онд 34 тэрбум ам.долларт хүрсэн. Хятадын гадаад худалдааны эргэлтэнд Оросын хувийн жин 2000 онд 1.69, байсан бол 2005 онд 2.05% болжээ. Цаашид хоёр улс худалдааны эргэлтээ 2010 онд 60-80 тэрбум ам.долларт хүргэхээр тохиролцсон.¹⁵

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины 2006 онд Хятадад хийсэн айлчлалын үр дүнд хоёр орны хооронд олон тооны баримт бичиг батлагдаж, үүний дотор Хятад нь Оросоос эрчим хүч нийлүүлэх тухай меморандумд гарын үсэг зурж, тус баримт бичиг зурснаар Хятад нь өөрийн эрчим хүчний аюулгүй байдлаа дээшлүүлж, АНУ, Баруун Европын орнуудын бодлогоос хараат байдлаас ангижирахад тус болно гэж тодорхойлжээ. Оросын талаас экспортын эрхийг Газпром, Роснефть, РАО ЕЭС гэсэн улсын компаниуд авчээ.

Хятадад газрын хий, тос, цахилгаан нийлүүлэх тухай хэд хэдэн меморандум нь урт хугацааны нөхцөлтэй бөгөөд ойрын 15 жилийн турш Орос нь Хятадад эрчим хүчний томоохон нийлүүлэгч болох юм. Өмнө нь Хятад улс нь газрын тосыг Персийн булан, Иранаас тус тус голлон импортлодог байв. Харин сүүлийн үед Орос, Казахстанас хоолой татаж эхэлсэнээр байдал дээрдэж буй төлөвтэй.

Эдгээр меморандумын дагуу 1 жилд 60-80 тэрбум кубометрын хий татах чадвартай 2 хоолойн барилга гүйцэтгэх юм. Эдгээр хоолойн тус бүрийн үнэ 10 тэрбум ам.доллар.¹⁶ Хятад улсад 1 жилд 35 тэрбум кубометрийн хий үйлдвэрлэдэг. Эхний “Алтай” хоолой нь /баруун хоолой/ 2011 онд барьж дуусгах бөгөөд Оросын Уралаас Алтайгаар дамжин Орос-Хятадын баруун хилээр орж ирэн Баруун Сибирийн газрын хийг Хятадын дотоодын “Баруун-Дорнод” хоолойтой холбох төлөвлөгөөтэй. 2 дахь хоолой нь баригдаж эхэлсэн бөгөөд Оросын Сахалинаас эх газар руу татагдаж, Хабаровск хотоос Хятадын нутагт орж ирэх юм. Эрхүү мужийн Ковыктинскийн хийн орд газрыг Хятадтай холбох тухай асуудал албан ёсоор тавигдаагүй юм. Гэвч тус хоолойг Хятад, Японы анхаарлыг маш ихээр татаж буй бөгөөд энэ салбарт хоёр улс өрсөлдөж байгаа юм.

Хоёр тал 1 жилд 10 сая тонны чадавхитай газрын тос боловсруулах Орос-Хятадын хамтарсан үйлдвэр байгуулах тухай тохиролцсон. Хятадын газрын тосны CNPC улсын компани нь Оросын Роснефть компанийн миноритар акци *squeeze out*¹⁷ авахыг хүссэн гэдгээ албан ёсоор илэрхийлсэн байна. 1 жилд 60 тэрбум кВт цаг цахилгаан Оросоос Хятад руу нийлүүлэхийн тулд Туруханы усан цахилгаан станцийн хүчин чадлыг 12 мянган МВт хүртэл нэмэгдүүлэх

шаардлагатай бөгөөд мөн газ, нүүрс дээр ажилладаг хэд хэдэн станцийн хучин чадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж төлөвлөжээ.

Олон улсын тавцан дахь Орос-Хятадын хамтын ажиллагаа:

2005 оны 6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 3-ны хооронд БНХАУ-ын дарга Ху Цзиньтао Орост айлчилсан. Хоёр орон гадаад бодлогын олон туйлт зарчим баримтладаг. Үүний тулд 2005 онд “ОХУ, БНХАУ хоёр хоорондын XXI зуунд олон улсын дэг журмын тухай хамтарсан тунхаглал”¹⁸-ыг баталсан билээ. Хоёр улс олон улсын тулгамдсан асуудлуудад хамтын хүчээр зүтгэж НҮБ-ын бүтцийг шинэчлэх, Ойрхи Дорнодын байдлыг зохицуулж хэвийн болгох, Ираны цөмийн зэвсгийн хөтөлбөр, үй олноор устгах зэвсгийг үл дэлгэрүүлэх болон бусад асуудалд ижил төстэй байр суурьтай байдаг.

Айлчлалын үр дүнд хоёр тал XXI зууны олон улсын дэг журмын тухай хамтарсан тунхаглал баталж, Орос, Хятад хоёр орчин үеийн олон улсын тавцан дахь асуудлын талаар ижил төстэй байр суурь баримталдаг гэдгээ илэрхийлсэн. Орос, Хятад хоёр нь олон улсын асуудлаар ижил төстэй байр суурьтай учир гадаад бодлогын асуудалд хамтран ажилладаг юм. Гадаад хэргийн сайд нарын хэмжээнд тогтмол уулзалт зохион байгуулж, ГХЯ-ны шугамаар байнгын зөвлөлгөөнүүд сайд нарын орлогч, газрын дарга нарын түвшинд болдог. Тайваний асуудлаар Тайвань нь Хятадын салшгүй хэсэг бөгөөд БНХАУ-ын Засгийн газар нь бүх Хятадыг төлөөлсөн хууль ёсны Засгийн газар гэж Оросын тал үздэг. Хятад нь Оросын талыг Тайваньтай албан бус харилцаа тогтоож, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёл, спортын салбарт хамтран ажиллахыг хүлээн зөвшөөрдөг.

Мөн Төвд нь Хятадын салшгүй хэсэг гэж үздэг. Үүний зэрэгцээ Чечений асуудалд БНХАУ нь Оросын талтай ижил төстэй байр суурь баримталж Оросын талын терроризм, салан тусгаарлах хөдөлгөөнтэй тэмцэх тэмцлийг нь дэмжсээр ирсэн.

Үүний зэрэгцээ Солонгосын хойгийн талаархи 6 талын хэлэлцээнд хамтран оролцож, олон улсын терроризм, салан тусгаарлах, шашны экстремизм, хил дамнасан гэмт хэрэг, хар тамхины худалдаа г.м. асуудалд ижил төстэй байр суурьтай гэдгээ илэрхийлдэг. Мөн хоёр улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгдөг. 2005 оны 7 дугаар сарын 5-нд болон ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтан¹⁹ дээр АНУ-д хандсан тунхаглалдаа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн орнууд болох Киргизстан, Узбекистанд байрладаг Афганистаны “Талибан” хөдөлгөөнтэй тэмцэх зорилготой Америкийн цэргийн баазуудаа бүрмөсөн гаргах хугацааг тодорхойлохыг АНУ-аас хүсчээ. Харин үүний хариуд АНУ-ын Конгресс 2005 оны 7 дугаар сарын 19нд “Хятад, Орос хоёр АНУ-г тус бүсээс шахан гаргах илт оролдлого

хийсэн” гэсэн үгийг тунхаглалаас харагдаж байв. Үүний дараа Узбекистаны ЗГ Карши-Ханабад баазыг хагас жилийн дотор чөлөөлөхийг АНУ-аас хүсэж албан ёсоор илэрхийлэв. 2005 оны 10 дугаар сард АНУ-ын төрийн бичгийн дарга Кондолиза Райс Киргизстанд ирж Ерөнхийлөгч Курманбек Бакиевтэй уулзаж, үүний дараа Киргизстанд байрлаж буй Ганси авиабааз руу шилжүүлсэн билээ.

Соёл, хүмүүнлэгийн харилцаа:

Орос-Хятадын найрамдал, энх тайван, хөгжлийн хорооны хүрээнд соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа өргөжиж байна. Хоёр тал жил болгон соёлын фестиваль зохион байгуулж, хамтарсан их, дээд сургууль байгуулах, халдвар-эрүүл ахуйн байгууллага, Орост Хятадын уламжлалт анагаах ухааныг суртатлах, аялал жуулчлал, спортын солилцоо, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх томоохон төслүүдийг төлөвлөсөн.

2006 онд Ерөнхийлөгч В.Путины айлчлалын үеэр Хятадад Оросын жил болж өнгөрсөн. Тус арга хэмжээний хүрээнд 250 гаруй арга хэмжээнүүд зохион байгуулагдаж, Оросын соёлын фестиваль, Оросын үндэсний үзэсгэлэн, Хөрөнгө оруулалтын долоо хоног болж, Оросын гүйцэтгэх засаглалын холбооны болон бүс нутгийн байгууллагууд өргөнөөр оролцсон. Оросын бүс нутгуудын танилцуулга болж, хоёр талын тулгамдсан асуудлаар конференц, семинарууд зохион байгуулагдаж, соёлын хөтөлбөр, үзэсгэлэнгүүд г.м. болон өнгөрчээ.

2007 онд Хятадын удирдагч Ху Цзиньтао ОХУ-д айлчлалын үеэр Орост Хятадын жил болж үүний нээлтэнд хоёр улсын тэргүүнүүд оролцов. Үүний хүрээнд 200 орчим томоохон арга хэмжээ зохион байгуулагдсан.²⁰

Хоёр талын хамтын ажиллагааны төлөв:

Орос, Хятадын хамтын ажиллагааны ирээдүйн төлөв нь хөрөнгө оруулалтын салбар юм. Үүнийг Оросын бүс нутаг болон бизнесийн хүрээнийхэн их сонирхдог. Үүний зэрэгцээ Хятадын үйлдвэр, компаниуд Орост хөрөнгө оруулахыг хүсэж байна. Нийт 657 хөрөнгө оруулалтын төсөл нь Хятадын хөрөнгө оруулалтын оролцоотойгоор хэрэгжиж байна. Хөрөнгө оруулалтын хэмжээ нь 320 сая ам.долларт хүрч, 2004 оныхоос 2 дахин илүү байна, харин Орост хийсэн Хятадын компаниудын нийт хэмжээ нь 977 сая ам.долларт хүрчээ.²¹ Хятадын компаниудын голлох салбар гэвэл, харилцаа холбоо, гэрийн цахилгаан барааны угсралт, мод боловсруулалт, арилжааны үл хөдлөх хөрөнгө, хөдөө аж ахуй, хувцасны үйлдвэр, нийтийн хоол юм. Цаашид ОХУ, БНХАУ хоёр эрчим хүчний салбарын машины үйлдвэр, өндөр технологи, мэдээллийн технологи, цөмийн эрчим хүч, авиаци, сансрын салбар, санхүү, зам тээвэр, томоохон төсөл дээр хамтран ажиллах сонирхолтой. Хоёр тал нь Эдийн засгийн онцгой бүсүүдийн /ЭЗОБ/ талаар хамтран ажиллах, санал, туршлага солилцох, модны гүнзгий боловсруулалт, далайн бүтээгдэхүүний боловсруулалт, зам тээвэр, хилийн боомтын дэд бүцийг сайжруулах, хил залгаа болон бусад субъектуудын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд зорьж байна.

Засгийн газрын тэргүүнүүдийн байнгын уулзалт зохион байгуулах Орос-Хятадын комиссийн хүрээнд шинээр Байгаль орчныг хамгаалах хамтын ажиллагааны Дэд комисс байгуулагдснаар сүүлийн жилүүдэд хоёр орны хооронд ЗГ болон ОХУ-ын субъектууд болон БНХАУ-ын мужуудын хоорондын түвшинд байгаль орчны хамгаалал, ашиглалтын салбарт хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж эхэлсэн. Тус байгууллагын хүрээнд тулгамдсан асуудал болох хил орчмын усны объектуудын чанар дээшлүүлэх, цэвэр байдлыг хангах, гол, далай, ой модны биоресурсыг хамгаалах, байгалийн гамшиг гарсан онцгой байдлын тохиолдолд харилцан шуурхай туслалцаа үзүүлэх, хил орчмын дархан цаазтай газруудыг хамгаалахад оршиж байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Гадаад бодлогын Үзэл баримтлал. http://www.mfa.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=35&Itemid=46 Монгол Улсын ГХЯ-ны вэб-хуудас.
2. <http://www.ln.mid.ru/Ns-rasia.nsf/1083b7937ae580ae432569e7004199c2/432569d80021985f43256a8c004d1562?OpenDocument> Договор о добрососедстве, дружбе и сотрудничестве между Российской Федерацией и Китайской Народной Республикой (Москва, 16 июля 2001 г.) ОХУ-ын ГХЯ-ны вэб-хуудас. МИНИСТЕРСТВО ИНОСТРАННЫХ ДЕЛ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ. ДЕПАРТАМЕНТ ИНФОРМАЦИИ И ПЕЧАТИ.
3. http://www.easternpromise.ru/press.php?doc_id=148 План действий по реализации положений Договора о добрососедстве, дружбе и сотрудничестве между Российской Федерацией и Китайской Народной Республикой /2005-2008 гт./
4. <http://russian.people.com.cn/31521/4234127.html> “Жэнь минь жибао” сонин. 10:00.24/03/2006 Визит В. Путина в Китай был плодотворным
5. <http://www.centrasia.ru/newsA.php4?st=1143181920> UPI: Визит Путина в Китай изменил баланс сил в Евразии 09:32 24.03.2006 Мартин Сифф (Martin Sieff), “United Press International”, США
6. http://russian.china.org.cn/international/txt/2006-09/22/content_2187544.htm 2005 оны Орос-Хятадын харилцааны үйл явдлын товчоон.
7. <http://www.mid.ru/ns-rasia.nsf/1083b7937ae580ae432569e7004199c2/abcb9cd00fafcaa6c3256e2800413897?OpenDocument> ОХУ-ын ГХЯ-ны вэб-хуудас.
8. Мөн тэнд.
9. <http://www.akdi.ru/gd/proekt/096937GD.SHTM> ДОПОЛНИТЕЛЬНОЕ СОГЛАШЕНИЕ МЕЖДУ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИЕЙ И КИТАЙСКОЙ НАРОДНОЙ РЕСПУБЛИКОЙ

О РОССИЙСКО-КИТАЙСКОЙ ГОСУДАРСТВЕННОЙ ГРАНИЦЕ НА ЕЕ ВОСТОЧНОЙ ЧАСТИ. 2005 оны 5 дугаар сарын 31-ний өдөр. N 52-ФЗ.

10. http://russian.china.org.cn/international/txt/2006-09/22/content_2187544.htm 2005 оны Орос-Хятадын харилцааны үйл явдлын товчоон.
11. http://www.ln.mid.ru/ns-vnpop.nsf/osn_copy/D80FA87976B0CCCC325704300315458 Орос, Хятадын стратегийн хамтын ажиллагаа. ОХУ-ын ГХЯ-ны вэб-сайт.
12. http://www.iicas.org/articles/ks_26_03_01.htm Международный евразийский институт экономических и политических исследований. Мы и Китай. Перспективы стратегического партнерства. Владимир Мясников, академик РАН, зам. директора Института Дальнего Востока РАН. Круглый стол.
13. <http://www.mid.ru/ns-rasia.nsf/1083b7937ae580ae432569e7004199c2/432569d80021985fc325704300315458?OpenDocument> ОХУ-ын ГХЯ-ны вэб-хуудас.
14. <http://www.army.lv/?s=544&id=213> “Военно-промышленный курьер” сонингоос авав. Реформа вооруженных сил КНР . Автор: Юрий СУМБАТЯН, профессор МГУ и РУДН, доктор философских наук, действительный член Академии военных наук, полковник в отставке.
15. http://www.rian.ru/m_kamynin/20060317/44459698.html и По российско-китайским отношениям.
16. Мөн тэнд.
17. Зарим орнуудын хууль тогтоомжийн дагуу хувьцаат байгууллагын дүрмэнд тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр миноритар акци буюу *squeeze out*-ыг томоохон түншэд зайлшгүй худалдаалах хувьцаа гэсэн нөхцөл байдаг.
18. http://www.kremlin.ru/interdocs/2006/03/21/1851_type72067_103421.shtml?type=72067 Совместная декларация Российской Федерации и Китайской Народной Республики о международном порядке в XXI веке. 2005 он. ОХУ-ын Ерөнхийлөгчийн вэб-хуудас.
19. <http://www.sectso.org/html/00029.html> Хроника главных событий в рамках “Шанхайской пятёрки” и Шанхайской организации сотрудничества (ШОС)
20. <http://www.chinacommerce.ru/content/view/14/1/Zhongguoshangmao>. Хятадын жил Орост болж өнгөрөв. 20. 05. 2007
21. http://www.rian.ru/m_kamynin/20060317/44459698.html и По российско-китайским отношениям.